



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХДАА
САНГИЙН ЯАМНААС ИРҮҮЛСЭН ЧИГЛЭЛИЙГ БАРИМТЛААГҮЙ БАЙНА

АУДИТЫН КОД: БӨА-2025/07-2-ШТА-НА

АУДИТЫН СЭДЭВ:
ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД САНАЛ ДҮГНЭЛТ ӨГӨХ

Цахим хуудас: www.audit.mn

Баян-Өлгий аймаг.

Өлгий хот

2025 оны 12 дугаар сар

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ж.Айгүл

Утас: 70422954 Цахим хаяг: Aigulj@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Назгүл, У.Ербол

Аудитор: М.Айнур, Б.Үүрийнтуяа, Ж.Назгүл, Р.Баярмаа,
Х.Еркебулан, Ш.Нурлан,

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу: Цахим хуудас: www.open.audit.mn

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товъёг:	4
Хавсралтын товъёг:	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	5
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	7
БҮЛЭГ 1. ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ БОДИТ ТООЦОО СУДАЛГААНД ҮНДЭСЛЭЭГҮЙ БАЙНА	8
1.1 Татварын орлогыг бодит тооцоо судалгаанд үндэслэж төлөвлөөгүй байна	8
1.2 Татварын бус орлогыг Сангийн яамны хянасан дүнгээс 2,700.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна	10
1.3 Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.....	11
БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХ САНГИЙН ЯАМНААС ӨГСӨН ТӨСВИЙН ХЯЗГААРТ НИЙЦҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА	12
2.1 Аймгийн ИТХ болон Засаг даргын тамгын газрын төсвийг 3,445.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна.....	12
2.2 Сангийн яамнаас хянасан орон тооны хязгаарыг баримтлаагүй, цалин, НДШ-ийн зардлын төсвийг 1,351.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна	14
2.3 Байр ашиглалттай холбоотой зардлын төсвийг тооцоо судалгаанд үндэслэж бодитой төлөвлөөгүй байна.	17
2.4 Орон нутгийн төсвийн төсөлд урсгал зардлыг үндэслэлгүй нэмэгдүүлсэн нь төсвийг хэмнэлттэй, үр ашигтай байх зарчимд нийцээгүй байна	22
3.1 Орон нутгийн хөгжлийн сангийн төсөл арга хэмжээг хууль тогтоомжид нийцүүлэн төлөвлөх шаардлагатай байна	22
3.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээ хууль тогтоомжид нийцээгүй, Замын сангийн төсвийг үр ашигтай төлөвлөөгүй байна.	24
Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.	27
ХАВСРАЛТ	28
ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ	31

Хүснэгтийн товъёг:

Хүснэгт 1	Суурь орлогын 2025 оны төсөв, хүлээгдэж буй гүйцэтгэл	8
Хүснэгт 2	Сангийн яамны хянаж ирүүлсэн дүнтэй харьцуулсан төсвийн төсөл	8-9
Хүснэгт 3	Татварын орлогын төсвийн төсөл	9
Хүснэгт 4	Татварын бус орлогын төсвийн төсөл	10
Хүснэгт 5	Торгуулийн орлогын судалгаа	10
Хүснэгт 6	Торгуулийн орлогын үлдэгдлийн судалгаа	10
Хүснэгт 7	Малын тоо толгойн албан татварын судалгаа	11
Хүснэгт 8	Аймгийн 2026 оны төсвийн зарлагын төслийн харьцуулалт	12
Хүснэгт 9	Цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн 2025 оны төлөвлөгөө, хүлээгдэж буй гүйцэтгэл	14-15
Хүснэгт 10	Цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын харьцуулсан судалгаа	15
Хүснэгт 11	Цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын судалгаа	15-16
Хүснэгт 12	Орон тооны судалгаа	16
Хүснэгт 13	Нэмж төлөвлөсөн орон тооны цалин, НДШ-ийн зардлын судалгаа	16
Хүснэгт 14	Тогтмол зардлын судалгаа	17
Хүснэгт 15	Тогтмол зардлын судалгаа-салбараар	17-18
Хүснэгт 16	Тогтмол зардлын харьцуулсан судалгаа	18
Хүснэгт 17	Халаалтын болон түрээсийн зардлын судалгаа	19
Хүснэгт 18	Халаалтын зардлын төсвийг нэмэгдүүлсэн сургуулиудын судалгаа	19-20
Хүснэгт 19	Цэцэрлэгүүдийн түрээсийн судалгаа	20-21
Хүснэгт 20	Халаалтын он дамжсан өрийн судалгаа	21
Хүснэгт 21	Аймгийн хөгжлийн 2026 оны жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй төсөл, арга хэмжээ	23
Хүснэгт 22	Зураг төсөв, техникийн тодорхойлолтгүй, хуульд заасан холбогдох зөвшөөрөл олгогдоогүй ТАХ-ний судалгаа	23-24
Хүснэгт 23	Аймгийн хөгжлийн 2026 оны жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй орон нутгийн хөрөнгө оруулалт	25
Хүснэгт 24	Зураг төсөв, техникийн тодорхойлолтгүй, хуульд заасан холбогдох зөвшөөрөл аваагүй ТАХ-ний судалгаа -Орон нутгийн хөрөнгө оруулалт	25
Хүснэгт 25	Зураг төсөвгүй, хуульд заасан холбогдох зөвшөөрөл аваагүй, нийт дүнгээр төлөвлөсөн Замын сангийн хөрөнгийн	26

Хавсралтын товъёг:

Хавсралт 1	Төсвийн суурь орлогын 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл	28
Хавсралт 2	Татварын орлогын төсвийн төсөл	29
Хавсралт 3	Төсвийн төлөвлөгөө, төсөл байгууллагаар	30

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1 дэх заалт, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаал, Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 онд гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн хийв.

Аудитын зорилт

Баян-Өлгий аймгийн Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд дүгнэлт гаргаж, санал зөвлөмж боловсруулан, дүнг аймгийн ИТХ, Засаг дарга, холбогдох байгууллагуудад танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилгыг хангахын тулд аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэв. Үүнд:

- Орон нутгийн 2026 оны төсвийн орлогын төсөл үндэслэлтэй эсэх;
- Орон нутгийн 2026 оны төсвийн зарлагын төсөл үндэслэлтэй эсэх;
- Орон нутгийн 2026 оны хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалтыг хууль журамд нийцүүлэн төлөвлөсөн эсэх

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Сангийн яаманд хүргүүлсэн Орон нутгийн 2026 оны төсвийн төсөл, Сангийн яамнаас хянаж ирүүлсэн Орон нутгийн 2026 оны төсөв, аймгийн Засаг даргаас аймгийн ИТХ-д өргөн мэдүүлэхээр боловсруулсан 2026 оны төсвийн төсөл, холбогдох бусад үйл ажиллагааг хамрууллаа.

Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Татварын хэлтэс, бусад холбогдох байгууллагуудаас төсвийн төсөлтэй холбоотой судалгаа мэдээ, баримт материалыг ашиглав.

Аудитын хязгаарлалт

Байхгүй

Аудитын арга шалгуур үзүүлэлт

Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аудитад АДБОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд тулгуурласан Төрийн аудит MNS6817-1:2020 Монгол Улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, аудитыг чиглүүлж гаргасан бусад заавар, аргачлал, гарын авлагыг нийтлэг мөрдөж Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж,

аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав. Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэлт хийх зэрэг судалгааны арга зүйг ашиглав.

**Аудитын
бүрэлдэхүүн, хугацаа**

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл хянан удирдаж, аудитын менежер Х.Женисбек чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Назгүл ахалж, ахлах аудитор У.Ербол, аудитор М.Айнур, Б.Үүрийнтуяа, Ж.Назгүл, Р.Баярмаа, Х.Еркебулан, Ш.Нурлан нарын бүрэлдэхүүнтэй баг хамтран гүйцэтгэв.

Аудитын талбарын ажлыг 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс 2025 оны 11 дүгээр сарын 27-ны хооронд гүйцэтгэж, тайлангийн төслийг бэлтгэн холбогдох үе шатны хяналтаар хянуулан баталгаажуулж, 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймгийн ИТХ, Засаг дарга нарт хүргүүлэхээр төлөвлөж ажиллав.

Хүндрэл бэрхшээл

Төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд багтаан гүйцэтгэх нь мэдээллийг бүрэн шинжлэх, иж бүрэн дүгнэлт гаргах аудитын үйл ажиллагааг хязгаарладаг. Мөн шалгагдагч байгууллагуудаас тайлбар танилцуулга, шаардлагатай мэдээ, судалгаа, тоо баримтыг иж бүрэн ирүүлээгүй, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Татварын хэлтсээс ирүүлж байгаа мэдээлэл зөрүүтэй байгаа нь хүндрэлтэй байлаа.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 01 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар 2026 оны төсвийн хязгаарт Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 оны суурь орлогыг 40,410.0 сая төгрөгөөр, суурь зарлагыг 53,477.9 сая төгрөгөөр, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 13,067.9 сая төгрөгөөр баталж, Төсвийн ерөнхийлөн захирагч нарт төсвийн төслийг баталсан төсвийн хязгаарт нийцүүлж боловсруулахыг үүрэг болгожээ.

Баян-Өлгий аймгийн 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийг Сангийн яаманд 2025 оны 07 дугаар сарын 31-ний өдөр хүргүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 8.4.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн саналаа жил бүрийн 07 дугаар сарын 25-ны дотор Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Төрийн аудитын байгууллага, Улсын Их хуралд хүргүүлж, нийтэд ил тод мэдээлэх” гэсэн заалттай нийцээгүй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч Сангийн яамд орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд орлогыг 35,874.8 сая төгрөгөөр, зарлагыг 88,559.5 сая төгрөгөөр тооцож хүргүүлсэн байна.

Монгол Улсын Их Хурлаас 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр баталсан “Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль”-аар Баян-Өлгий аймгийн орон нутгийн төсвийн суурь орлогыг 34,164.9 сая төгрөгөөр, суурь зарлагыг 47,754.4 сая төгрөгөөр, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 13,589.5 сая төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс аймгийн Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 10,828.9 сая төгрөгөөр баталсан байна. Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг өмнөх оноос 5,760.5 сая төгрөгөөр буурсан байна.

Сангийн яамнаас тус аймгийн орон нутгийн 2026 оны төсвийн суурь орлогыг 34,164.9 сая төгрөгөөр, суурь зарлагыг 47,754.4 сая төгрөгөөр хянаж ирүүлсэн байна.

Сангийн сайдын 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн аймгийн Засаг даргад хүргүүлсэн “Төсөв хүргүүлэх тухай” 01/10180 дугаар албан бичгийн хавсралт 1-д орон нутгийн 2026 оны төсвийн төслийг боловсруулахад баримтлах чиглэл, удирдамжийг ирүүлсэн байна.

Аймгийн Засаг дарга 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 1-01/1614 тоот албан бичгээр 2026 оны төсвийн төслийг дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн.

Баян-Өлгий аймгийн 2026 оны орон нутгийн төсвийн төсөл нь Төсвийн тухай хуулийн 31.1-д заасан шаардлагыг бүрэн хангаагүй, 31.2-т заасны дагуу жилийн төсвийн хязгаарт багтаагүй саналаа төсвийн төслийн тооцоонд тусгахгүйгээр холбогдох үндэслэл, тайлбарын хамт ирүүлээгүй, 31.4 дэх хэсгийн 31.4.1-31.4.6-д заасан тооцоолол, судалгаануудыг ирүүлээгүй байна.

Төсвийн төслийг боловсруулахдаа Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 7.5.6-д “аймаг, нийслэлийн Засаг дарга хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг төсвийн захирагч бүрээр гаргаж төсвийн төслийн хавсралт байдлаар боловсруулж, дараах зүйлийг тусгана” гэсэн шаардлагыг хангаагүй байна.

Орон нутгийн төсвийн төсөлд 2026 оны төсвийн суурь орлогыг 44,901.5 сая төгрөгөөр, суурь зарлагыг 58,490.9 сая төгрөгөөр тусгасан байна.

Аймагт төвлөрүүлэх орлогыг 19,835.7 сая төгрөгөөр, аймагт төвлөрүүлэх тэгшитгэлийг Цагааннуур тосгонд 331.9 сая төгрөгөөр, Өлгий сумд 15,302.4 сая төгрөгөөр, бусад сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг 9,388.1 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

БҮЛЭГ 1. ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ БОДИТ ТООЦОО СУДАЛГААНД ҮНДЭСЛЭЭГҮЙ БАЙНА

1.1 Татварын орлогыг бодит тооцоо судалгаанд үндэслэж төлөвлөөгүй байна

Орон нутгийн 2025 оны төсвийн суурь орлого хүлээгдэж буй гүйцэтгэлээр 2,346.8 сая төгрөгөөр тасрах төлөвтэй байна

Аймгийн орон нутгийн 2025 оны суурь орлогын төлөвлөгөө 38,389.1 сая төгрөг ба аймгийн ИТХ-ын тогтоолоор 1,542.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгож баталсан байна. Сумуудын ИТХ-ын тогтоолоор нэмж баталсан орлогын төлөвлөгөөг нэмж тооцоход /Өлгий, Бугат, Алтанцэгц сумын тодотгож баталсан дүн ороогүй/ суурь орлогын нийт дүн 42,113.4 сая төгрөг байна.

Хүснэгт 1. Суурь орлогын 2025 оны төсөв, хүлээгдэж буй гүйцэтгэл (сая төгрөг)

ҮЗҮҮЛЭЛТ	2025 оны суурь орлого Тодотгосон төлөвлөгөө			
	Төлөвлөгөө	Аймгийн ИТХ-ын тодотгож баталсан хязгаар	Сумуудын ИТХ-ын тогтоолоор нэмж тодотгож баталсан дүн	Хүлээгдэж буй гүйцэтгэл
НИЙТ ОРЛОГО	38,389.15	39,931.92	42,113.38	38,671.68
ТАТВАРЫН ОРЛОГО	35,566.07	34,538.48	36,591.21	35,496.33
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,823.07	5,393.44	5,522.17	3,175.35

Эх сурвалж: Аудитын судалгаа

Орон нутгийн 2025 оны суурь орлого хүлээгдэж буй гүйцэтгэлээр 38,671.7 сая төгрөг гарахаар байгаа нь 3,441.7 сая төгрөгөөр тасрах төлөвтэй байна. Үүнээс татварын орлого 1,094.9 сая төгрөгөөр, татварын бус орлого 2,346.8 сая төгрөгөөр тасрах төлөвтэй байна. Орлогын нэр төрлөөр авч үзэхэд хөрөнгийн орлого 1,010.7 сая төгрөгөөр давж биелэгдэх, бусад татварын болон татварын бус орлогын төлөвлөгөө тасрах төлөвтэй байна. /Хавсралт №1/

Орон нутгийн татварын орлогыг Сангийн яамны хянасан дүнгээс 8,036.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна

Сангийн яамнаас төсвийг хянахдаа орон нутгийн суурь орлогыг өмнөх оноос нэмэгдүүлэн тооцож, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг жил бүр бууруулж баталж байгаа тул цаашид орон нутгийн төсвийн суурь орлогыг нэмэгдүүлэх нөөц боломжуудыг бүрэн тооцож төлөвлөх шаардлагатай байна.

Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд суурь орлогыг 44,901.5 сая төгрөгөөр төлөвлөж Сангийн яамны хянаж ирүүлсэн дүнгээс 10,736.6 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Үүнд татварын орлогыг 8,036.5 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 2,700.0 сая төгрөгөөр нэмэгдүүлжээ.

Хүснэгт 2. Сангийн яамны хянаж ирүүлсэн дүнтэй харьцуулсан төсвийн төсөл (сая төгрөг)

Орлогын нэр төрөл	Хүлээгдэж буй гүйцэтгэл	Сангийн яамны хянаж ирүүлсэн дүн	2026 оны төсвийн төсөл	Зөрүү
-------------------	-------------------------	----------------------------------	------------------------	-------

“Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх” нийцлийн аудитын тайлан

	1	2	3	4=3-2
НИЙТ ОРЛОГО	38,671.68	34,164.92	44,901.47	10,736.56
ТАТВАРЫН ОРЛОГО	35,496.33	32,659.92	40,696.47	8,036.56
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,175.35	1,505.00	4,205.00	2,700.00

Эх сурвалж: Аудитын судалгаа

Орон нутгийн 2026 оны төсвийн орлогын төсөл нь Засгийн газрын 2025 оны 01 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Баян-Өлгий аймгийн 2026 оны суурь орлогын хязгаартай харьцуулахад 4,491.5 сая төгрөгөөр илүү байна.

Хүснэгт 3. Татварын орлогын төсвийн төсөл (сая төгрөг)

Орлогын нэр төрөл	Хүлээгдэж буй гүйцэтгэл	Сангийн яамны хянаж ирүүлсэн дүн	2026 оны төсвийн төсөл	Зөрүү
	1	2	3	4=3-2
ТАТВАРЫН ОРЛОГО	35,496.33	32,659.92	40,696.47	8,036.56
Орлогын албан татвар	35,496.33	32,659.9	40,696.5	8,036.6
Хувь хүний орлогын албан татвар	32,210.3	29,710.0	36737.06	7,027.1
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(2,435.37)	(2,450.0)	(2,450.0)	-
Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	906.22	1,150.0	1,150.0	-
Хөрөнгийн албан татвар	1,801.72	1,420.5	2,430.0	1,009.5
Бусад татвар	3,013.44	2,829.4	2,829.4	-
Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,539.00	1,437.4	1,437.4	-

Эх сурвалж: Аудитын судалгаа

Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогыг 5,520.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөжээ. 2026 онд багш, эмч нарын цалин нэмэгдэхтэй холбоотой энэхүү орлогыг нэмэгдүүлж төлөвлөсөн гэх боловч дэлгэрэнгүй тооцоо судалгаагаа ирүүлээгүй.

Үйл ажиллагааны орлогыг 504.2 сая төгрөгөөр, хөрөнгийн орлогыг 1,002.8 сая төгрөгөөр, үл хөдлөх хөрөнгийн албан татварыг 450.0 сая төгрөгөөр, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг 559.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж бусад татварын орлогыг Сангийн яамны хянасан дүнгээр төлөвлөсөн байна.

Тайлант оны татварын орлогын хүлээгдэж буй гүйцэтгэлийг 35,496.3 сая төгрөгөөр тооцсон нь Сангийн яамны хянасан төсвөөс 2,836.4 сая төгрөгөөр илүү байна.

Тус аймагт төсвийн хөрөнгө оруулалтаар зам тавих ажил, хувийн хэвшлийн хөрөнгөөр орон сууцны барилга ихээр баригдаж, тоосгоны үйлдвэрүүд ажиллаж байгаа боловч түгээмэл тархацтай ашигт матмал ашигласны төлбөр хураамжаас орох орлого бага байгаа нь ногдуулалт, төлөлтөд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна.

Төсвийн төсөлд төсөлд сумуудын төсөв орох малын тоо, толгойд ногдуулах албан татварыг төлөвлөөгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 21.2-т “Орон нутгийн төсөв нь аймаг, нийслэл, улсын зэрэглэлтэй хот, сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвөөс бүрдэнэ” гэсэн заалттай нийцээгүй байна.

1.2 Татварын бус орлогыг Сангийн яамны хянасан дүнгээс 2,700.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна

Орон нутгийн төсвийн төсөлд татварын бус орлогыг 4,205.0 сая төгрөгөөр төлөвлөсөн нь Сангийн яамны хянасан дүнгээс 2,700.0 сая төгрөгөөр, хүлээгдэж буй гүйцэтгэлээс 1,029.7 сая төгрөгөөр илүү байна.

Торгуулийн орлогыг 800.0 сая төгрөгөөр, нэр заагдаагүй бусад орлогыг 1,900.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна.

Татварын бус орлогын 48 хувийг торгуулийн орлогоос, 51.4 хувийг нэр заагдаагүй бусад орлогоос, 1 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлогоос оруулахаар төлөвлөжээ.

Хүснэгт 4. Татварын бус орлогын төсвийн төсөл (сая төгрөг)

Орлогын нэр төрөл	Хүлээгдэж буй гүйцэтгэл	Сангийн яамны хянаж ирүүлсэн дүн	2026 оны төсвийн төсөл	Зөрүү
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,175.35	1,505.00	4,205.00	2,700.00
Торгуулийн орлого	1,516.57	1,200.00	2,000.00	800.00
Төсвийн байгууллагын өөрийн орлого	65.00	45.00	45.00	-
Нэр заагдаагүй бусад орлого	1,593.78	260.00	2,160.00	1,900.00

Эх сурвалж: Аудитын судалгаа

Өмнөх онуудын гүйцэтгэлээс харахад татварын бус орлогын 41-42 хувийг торгуулийн орлогоос, орон нутгийн төсвийн 3-аас 5 хувийг торгуулийн орлогоос бүрдүүлж ирсэн байна.

Хүснэгт 5. Торгуулийн орлогын судалгаа (сая төгрөг)

Он	Орон нутгийн нийт орлого	Татварын бус орлого	Торгуулийн орлого	Торгуулийн орлогын	
				Нийт орлогод эзлэх хувь	Татварын бус орлогод эзлэх хувь
2023 он	20,911.20	2,362.40	974.2	5%	41%
2024 он	36,463.20	2,821.90	1175.5	3%	42%

Эх сурвалж: Хүү торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хийсэн аудитын тайлангаас

Тус газраас 2025 онд “Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын дүнгээс үзэхэд 2024 онд хүүгийн орлого төлөвлөгдөөгүй боловч торгуулийн орлогоос 1,588.3 сая төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 1,233.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн. Эрх бүхий байгууллагуудаас ногдуулсан төлөгдөөгүй 12 байгууллагад 617.6 сая төгрөгийн торгуулийн үлдэгдэл байна.

Хүснэгт 6. Торгуулийн орлогын үлдэгдлийн судалгаа (сая төгрөг)

Эхний үлдэгдэл /2023.01.01/	2023 оны ногдуулалт	2023 оны төлөлт	Үлдэгдэл /2023.12.31/	2024 оны ногдуулалт	2024 оны төлөлт	Үлдэгдэл /2024.12.31/
58.1	1362.7	1158.3	262.5	1,588.30	1,233.20	617.6

Эх сурвалж: Хүү торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хийсэн аудитын тайлангаас

Торгуулийн орлогын ногдуулалт, төвлөрүүлэлтэд тавих хяналтын сайжруулах шаардлагатай байна.

1.3 Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна

Сумдын ИТХ-аар Малын тоо, толгойн албан татварын орлогод 2023 онд 708.0 сая төгрөгөөр төлөвлөж 318.0 сая төгрөгийг, 2024 онд 333.4 сая төгрөг төлөвлөж 268.9 сая төгрөгийг төвлөрүүлсэн. Харин 2025 онд 208.1 сая төгрөг төлөвлөж, хүлээгдэж буй гүйцэтгэлээр 233.8 сая төгрөгийн орлого орох төлөвтэй байна.

Аймгийн 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүнгээс үзэхэд Алтай, Алтанцөгц, Дэлүүн, Өлгий сум, Цагааннуур тосгон малын тоо толгойн албан татварыг төлөвлөөгүй бол 2025 онд Алтай, Алтанцөгц, Бугат, Ногооннуур, Толбо, Цэнгэл, Сагсай, Өлгий сум, Цагааннуур тосгон төлөвлөөгүй байна.

Малын тоо толгойн албан татвараас 2025 онд Баяннуур сум 20.0 сая төгрөг, Булган сум 37.8 сая төгрөг, Буянт сум 25.0 сая төгрөг, Дэлүүн сум 40.0 сая төгрөг, Улаанхус сум 85.2 сая төгрөг оруулахаар төлөвлөсөн байна.

Хүснэгт 7. Малын тоо толгойн албан татварын судалгаа (сая төгрөг)

Орлого	2023 он		2024 он		2025 он	
	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	ХБГ
Малын тоо толгойн татвар	708.0	318.0	333.4	268.9	208.1	233.8

Эх сурвалж: Аудитын судалгаа

Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн дараах заалтуудын хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд:

- 4 дүгээр зүйлийн 4.1-д “Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малыг өмчилж буй малчин, мал бүхий этгээд нь албан татвар төлөгч байна”,
- 5.1-д “Албан татвар төлөгчийн өмчилж буй Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малын тоо толгойд албан татвар ногдуулна”,
- 5.2-т “Тухайн татварын жилд албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн татварын алба тооцож, төлбөл зохих албан татварыг тодорхойлно”;

Дээрх байдлаас дүгнэлт хийж үзэхэд сумуудад малын тоо толгойн албан татварыг төвлөрүүлэх асуудал хангалтгүй байгаа тул Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласнаар сумуудын төсвийн орлогыг нэмэгдүүлэх боломж байна.

Малын тоо толгойн албан татварыг 2026 онд өмнөх онуудын түвшнээс бууруулахгүй төлөвлөх талаар чиглэл өгч, хуулийн хэрэгжилтийг хангуулах саналтай байна.

Орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх талаар дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Орон нутгийн төсвийн орлогыг бодитой тооцоо судалгаанд үндэслэж биелэгдэх боломжтой байдлаар төлөвлөх;

БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХ САНГИЙН ЯАМНААС ӨГСӨН ТӨСВИЙН ХЯЗГААРТ НИЙЦҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА

2.1 Аймгийн ИТХ болон Засаг даргын тамгын газрын төсвийг 3,445.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна

Сангийн яам Баян-Өлгий аймгийн 2026 оны орон нутгийн төсвийн суурь зарлагыг 47,754.4 сая төгрөгөөр хянаж ирүүлсэн. Аймгийн Засаг даргаас боловсруулсан орон нутгийн төсвийн төсөлд 2026 оны суурь зарлагыг Сангийн яамны хянасан дүнгээс 10,736.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 58,490.9 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Хүснэгт 8. Аймгийн 2026 оны төсвийн зарлагын төслийн харьцуулалт (сая төгрөг)

Үзүүлэлт	2025 оны тодотгосон төсөв	Сангийн яамнаас хянагдсан	Аймгийн ИТХ-д өргөн мэдүүлсэн	Зөрүү
	a	b	c	d=c-b
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	59,293.40	47,754.40	58,490.90	10,736.50
УРСГАЛ ЗАРДАЛ	53,003.10	43,762.10	51,329.70	7,567.60
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	52,541.90	41,775.60	49,101.60	7,326.00
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	23,063.60	18,898.40	20,531.20	1,632.80
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,692.30	2,353.90	2,566.40	212.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,844.90	15,636.90	17,036.70	1,399.80
Хангамж, бараа материалын зардал	690.2	416.6	570.8	154.2
Нормативд зардал	288.6	211.4	223.6	12.2
Эд хогшил, урсгал засварын зардал	747.9	494.1	593.2	99.1
Томилолт, зочны зардал	302	106.9	218.1	111.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,096.10	2,477.90	2,742.60	264.7
Бараа үйлчилгээний бусад зардал	3,816.40	1,179.30	4,619.10	3,439.80
УРСГАЛ ШИЛЖИЛЭГ	461.1	1,986.50	2,228.10	241.6
Бусад урсгал шилжүүлэг	461.1	1,986.50	2,228.10	241.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,290.40	3,992.30	7,161.20	3,168.90
Их засвар	4,837.40	2,357.30	2,357.30	0
Бусад	1,453.00	1,635.00	4,803.90	3,168.90
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	59,293.40	47,754.40	58,490.90	10,736.50
Улсын төсвөөс санхүүжих	-	47,704.40		-47,704.40
Орон нутгийн төсвийн санхүүжих	59,228.40	5	58440.9	58,440.90
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	65	45	45	-

Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын тогтоолын хавсралт, Сангийн яамнаас хянаж ирүүлсэн төсөв, аймгийн ТЕЗ-аас ирүүлсэн төсвийн төсөл

Цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 1,632.8 сая төгрөгөөр, НДШ-ийн зардлыг 212.5 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1,399.8 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 154.2 сая төгрөгөөр, нормативд зардлыг 12.2 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 99.1 сая төгрөгөөр, томилолт зочны зардлыг 111.2 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийн хураамжийн зардлыг 264.7 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 3,439.8 сая төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардлыг 241.6 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 3,168.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн зарлагын 87.7 хувийг урсгал зардал, 12.3 хувийг хөрөнгө оруулалтын зардал эзэлж байна. Урсгал зардлын 95.6 хувийг бараа үйлчилгээний зардал, 4.3 хувийг урсгал шилжүүлэг эзэлж байна.

Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд аймгийн ИТХ-ын төсвийг 680.0 сая төгрөгөөр, аймгийн ЗДТГ-ын төсвийг 4,560.5 сая төгрөгөөр, сумын ЗДТГ-ын төсвийг 1,826.3 сая төгрөгөөр, Асрамжийн газрын төсвийг 29.6 сая төгрөгөөр, МҮОНРТ-ийн Баян-Өлгий дахь салбарын төсвийг 110.2 сая төгрөгөөр, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны төсвийг 65.4 сая төгрөгөөр, Сум дундын ойн ангийн төсвийг 126.8 сая төгрөгөөр, Худалдан авах ажиллагааны газрын төсвийг 178.8 сая төгрөгөөр, орон нутгийн хөрөнгө оруулалтын төсвийг 3,168.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төсвийг 323.3 сая төгрөгөөр, Байгаль орчны газрын төсвийг 512.2 сая төгрөгөөр бууруулсан байна.

Засгийн газрын 2025 оны 37 дугаар тогтоолд үндэслэн аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын жагсаалтад үндэслэн аймгийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн А/323 дугаар захирамжаар Архивын хэлтсийн бүтэц орон тоог 14 орон тоогоор баталж, үйл ажиллагаанд 353.6 сая төгрөг төлөвлөсөн байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төсвийг 680.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсний дотор цалингийн зардлыг 208.1 сая төгрөгөөр, Өлгий сумын олон нийтийн цагдаагийн урамшуулалтай холбоотой нийтлэг ажил үйлчилгээ төлбөр хураамжийн зардлыг 490.0 сая төгрөгөөр, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 200.0 сая төгрөг, гамшгаас эрсдэлийг бууруулах зардалд 100.0 сая төгрөгийг нэмэгдүүлсэн байна.

Мөн бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо интернэт, бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс, урсгал засварын зардал, албан томилолт, мэдээллийн технологийн үйлчилгээ, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх үйлчилгээ, бараа үйлчилгээний бусад зардлыг 119.0 сая төгрөгөөр нэмж төлөвлөсөн байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын төсвийг 4,560.5 сая төгрөгөөр нэмэгдүүлсний дотор цалин хөлсний зардлыг 849.0 сая төгрөгөөр, Засаг даргын нөөц хөрөнгийг 280.0 сая төгрөгөөр, ангилагдаагүй зардлыг 3,230.0 төгрөгөөр, мөн тээвэр шатахуун, нормын хувцас, зөөлөн эдлэл, эд хогшил урсгал засвар, дотоод албан томилолт, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлыг 313.7 сая төгрөгөөр нэмж төлөвлөсөн байна.

Аймгийн Засаг даргын ангилагдаагүй зардалд 25 арга хэмжээнд 3,230.0 сая төгрөг төлөвлөсөн нь өмнөх оноос 2.6 дахин нэмэгдсэн байна.

Тухайлбал: Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэх бусад хөтөлбөрүүдэд 200.0 сая төгрөг, Шүүхийн шийдвэр гарсан халаалтын өр төлбөрт 600.0 сая төгрөг, Цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааны зардалд 500.0 сая төгрөгөөр төлөвлөжээ.

Энэ нь Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хорооноос 2025 оны 08 дугаар сард “Суат” ХХК-нд хийгдсэн шалгалтаар “Польшийн засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр шинэ цэвэрлэх байгууламж ашиглалтад орсон нь иргэдийг эрүүл, аюулгүй орчинд ая тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлсэн чухал ач холбогдолтой хөрөнгө оруулалт болсон бөгөөд тус байгууллага нь урт хугацаанд үндсэн үйл ажиллагааны орлогоор цэвэрлэх байгууламжийн ашиглалтын зардлыг хариуцах боломжгүй” гэсэн дүгнэлт гарсан.

Үүнтэй холбоотой “Шинэ цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааны жилийн зардлыг бодитоор төсөвлөж, жил бүр аймаг орон нутгийн төсөвт тусгуулах. Цаашид үйл ажиллагааг нь хэвийн, найдвартай явуулах нөхцөлөөр хангах шаардлагатай” гэсэн зөвлөмж өгсөн байна.

Нийтээр тэмдэглэх баярын үйл ажиллагааны зардалд 160.0 сая төгрөг, жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжих, улсын үзэсгэлэнд оролцуулах зардалд 150.0 сая төгрөг, аялал жуулчлалыг дэмжих арга хэмжээний зардалд 180.0 сая төгрөг, Боловсрол, эрүүл мэндийн салбарыг дэмжих, судалгаа шинжилгээ хийх зардалд 300.0 сая төгрөг, аймгийн сурталчлах контент бэлтгэхэд 16.0 сая төгрөг, гадаадын хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, газар тариалан, чинээлэг малчныг дэмжих зардалд 78.0 сая төгрөг, ИТМ-mongolia аялал жуулчлалын үзэсгэлэнд дэмжлэгт 40.0 сая төгрөг, Аймгийн баяр наадмын зардалд 80.0 сая төгрөг, оны шилдгүүдийн шагналд 50.0 сая төгрөг, цагаан сарын аваргуудын шагналд 70.0 сая төгрөг төлөвлөсөн нь Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцээгүй байна.

Аймгийн төвийн камер арчилгааны төвд 398.0 сая төгрөг төлөвлөсөн нь урьд оноос 358.0 сая төгрөгөөр нэмэгджээ. Тус төвийн дарга 1, инженер сүлжээ хариуцсан ажилтан 5, үйлчилгээний ажилтан 3, нийт 9 орон тооны цалингийн зардалд 294.1 сая төгрөг, үйл ажиллагааны урсгал зардалд 104.2 сая төгрөг төлөвлөсөн байна.

Орон нутгийн төсвийн төсөлд зарлага бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх дараах саналуудыг хүргүүлж байна. Үүнд:

1. Сангийн яамнаас Архивын хэлтэст төсөв батлаагүй бөгөөд төсвийн төсөлд 353.6 сая төгрөгөөр тусдаа байгууллага болгож төлөвлөсөн байна. Үүнээс: 331.8 сая төгрөг нь цалин, НДШ-ийн зардал, 21.8 сая төгрөг нь бусад байна. Архивын хэлтсийг бусад аймгийн жишгээр аймгийн ЗДТГ-ын бүрэлдэхүүнд оруулж үйл ажиллагааны зардал 21.8 сая төгрөгийг хасах.

2. Аймгийн төвийн камер арчилгааны төвийг аймгийн ЗДТГ-ын бүрэлдэхүүнд нэгтгэснээр үйл ажиллагааны урсгал зардал 104.2 сая төгрөг, үйлчилгээний 3 ажилтан /нягтлан бодогч, цахилгаанчин, үйлчилгээний ажилтан/-ны цалингийн зардал 78.6 сая төгрөгийг хэмнэх боломжтой байна.

3. Засаг даргын ангилагдаагүй зардлын төсвөөс холбогдох хууль тогтоомжид нийцээгүй арга хэмжээнүүдэд төлөвлөсөн зардлыг 50 хувь буюу 527.0 сая төгрөгийн төсвийг хасах.

4. Аймгийн ИТХ-ын үйл ажиллагааны зардлын төсвөөс 119.0 сая төгрөг, аймгийн Засаг даргын тамгын газрын төсвөөс 313.7 сая төгрөгийг тус тус хасах.

2.2 Сангийн яамнаас хянасан орон тооны хязгаарыг баримтлаагүй, цалин, НДШ-ийн зардлын төсвийг 1,351.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна

Монгол Улсын Засгийн газраас 2025 онд багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын орон тоог 9 хувиар бууруулах бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Аймгийн Орон нутгийн 2025 оны төсвийн тодотголоор цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын төсвийг 4,424.2 сая төгрөгөөр бууруулж 25,755.9 сая төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт 9. Цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн 2025 оны төлөвлөгөө, хүлээгдэж буй гүйцэтгэл (сая төгрөг)

Үзүүлэлт	2025 оны				
	Анх баталсан төсөв	Тодотгосон төсөв	Зөрүү	ХБГ	Зөрүү

“Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх” нийцлийн аудитын тайлан

	1	2	3=2-1	4	5=4-2
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	27,290.60	23,063.60	-4,227.00	20,404.10	-2,659.50
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,889.50	2,692.30	-197.2	2,895.80	203.50
Дүн	30,180.10	25,755.90	-4,424.20	23,299.90	-2,456.00

Эх сурвалж: Аудитын судалгаа

Цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын 2025 оны төсөв хүлээгдэж буй гүйцэтгэлээр 405.1 сая төгрөгөөр хэтрэх төлөвтэй байна.

Багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын орон тоог 9 хувь бууруулах бодлогын арга хэмжээг 2026 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр тооцож Монгол Улсын 2026 оны төсвийн төслийг боловсруулсан.

Сангийн сайдаас аймгийн Засаг даргад эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын чиг үүрэгт дүн шинжилгээ хийж бүтэц, зохион байгуулалтын оновчтой хувилбарыг сонгож нэгтгэн зохион байгуулах замаар Улсын Их Хурлаас баталсан Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд аймгийн суурь зарлагад туссан төсөв, цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан үйл ажиллагаа явуулах чиглэл ирүүлсэн байна.

Хүснэгт 10. Цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын харьцуулсан судалгаа (сая төгрөг)

Үзүүлэлт	2025 оны тодотгосон төсөв	Сангийн яамны хянаж ирүүлсэн дүн	Орон нутгийн 2026 оны төсвийн төсөл	Зөрүү	
	1	2	3	4=2-1	5=3-2
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	23,063.60	18,898.40	20,531.20	-4,165.20	1,632.80
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,692.30	2,353.90	2,566.40	-338.4	212.5
Дүн	25,755.90	21,252.30	23,097.60	-4,503.60	1,845.30

Сангийн яам 2026 оны цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын төсвийг 21,252.3 сая төгрөгөөр хянаж ирүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн төсөлд 2026 оны цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын төсвийг Сангийн яамнаас хянасан дүнгээс 1,845.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж 23,097.6 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Хүснэгт 11. Цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын судалгаа (сая төгрөг)

Байгууллагын нэр	2025 оны ХБ Гүйцэтгэл	Сангийн яамны хянасан дүн	2025 оны төсвийн төсөл	Зөрүү
	1	2	3	4=3-2
Сумуудын ИТХурал	2,397.1	2,709.5	2,369.0	-340.5
Сумуудын ЗДТГазар	13,318.6	12,269.4	12,500.4	231.0
Аймгийн ИТХурал	759.2	514.9	723.0	208.1
Аймгийн ЗДТГазар	2,747.7	2,790.1	3,971.3	1,118.2
Орон нутгийн өмчийн газар	548.6	311.7	309.2	-2.5
Санхүүгийн хяналт, аудитын алба	433.2	312.3	377.6	65.3
Сум дундын ойн анги	287.7	175.1	278.5	103.4
Байгаль орчны газар	1,347.80	1,056.10	1,210.70	154.6
Асрамжийн газар	335.4	292.9	304.1	11.2
Орон нутгийн олон нийтийн радио, телевиз	757.7	590.6	678.3	87.7

“Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх” нийцлийн аудитын тайлан

Худалдан авах ажиллагааны газар	366.9	233.7	375.5	141.8
Дүн	23,299.90	21,256.30	23,097.60	1,841.30

Эх сурвалж: Аудитын судалгаа

Цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын төсвийн төслийг байгууллага бүрээр Сангийн яамны хянасан дүнтэй харьцуулж үзэхэд сумдын ИТХ-ын төсвийг 340.5 сая төгрөгөөр, Орон нутгийн өмчийн газрын төсвийг 2.5 сая төгрөгөөр бууруулж, бусад бүх байгууллагын төсвийг нэмэгдүүлж төлөвлөсөн байна.

Үүнээс: Аймгийн Засаг даргын тамгын газрын цалин, нийгмийн даатгалыг шимтгэлийн зардлын төсвийг 1,220.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна.

Хүснэгт 12.

Орон тооны судалгаа

Байгууллагын нэр	Аймгийн ИТХ-аас тодотгож баталсан 2025 оны орон тоо	Одоо ажиллаж байгаа орон тоо	Зөрүү	Сангийн яамнаас хянасан орон тоо	2026 оны төсвийн төсөлд тусгасан орон тоо	Зөрүү
	1	2	3=2-1	4	5	6=5-4
Аймаг, сумын ЗДТГ	417	538	119	391	419	28
Аймаг, сумын ИТХ	57	61	4	51	57	6
Орон нутгийн өмчийн газар	6	6	0	6	6	0
Санхүүгийн хяналт, аудитын алба	9	8	1	6	9	3
Сум дундын ойн анги	9	11	-2	6	9	3
Байгаль орчны газар	37	35	2	35	38	3
Асрамжийн газар	10	11	-1	10	10	0
Орон нутгийн олон нийтийн радио, телевиз	18	18	0	16	18	2
Худалдан авах ажиллагааны газар	6	13	-7	6	6	0
Дүн	569	701	-132	527	572	45

Эх сурвалж: Аудитын судалгаа

Аймгийн орон нутгийн төсвийн байгууллагуудын 2025 оны батлагдсан орон тоо 569 ба одоо ажиллаж байгаа орон тоо 701 буюу 5 байгууллагад 6 орон тоо дутуу, 22 байгууллагад 138 орон тоо илүү байна.

Орон нутгийн төсвийн төсөлд орон тоог 572-оор төлөвлөсөн нь Сангийн яамнаас хянаж ирүүлсэн орон тооны хязгаараас 45 орон тоогоор илүү байна.

Хүснэгт 13. Нэмж төлөвлөсөн орон тооны цалин, НДШ-ийн зардлын судалгаа (сая төгрөг)

Байгууллагын нэр	Илүү орон тоо	Цалин, НДШ-ийн зардал
Аймгийн ИТХурал	7	208.1
Аймгийн Засаг даргын тамгын газар	24	745.4
Дэлүүн сумын ЗДТГазар	1	32.4
Өлгий сумын сумын ЗДТГазар	2	54.3
Санхүүгийн хяналт, аудитын алба	3	104.2
Сум дундын ойн анги	3	72.6
Байгаль орчны газар	3	79.5
Орон нутгийн олон нийтийн радио, телевиз	2	55
Дүн	45	1351.5

Эх сурвалж: Аудитын судалгаа

Сангийн яамны хянасан орон тооноос илүү төлөвлөсөн 45 орон тооны цалин, НДШ-ийн зардлын төсөв 1,351.5 сая төгрөг байна.

Аймгийн орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд Засгийн гараас хэрэгжүүлж байгаа төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах бодлогыг баримтлаагүй байна.

Цалин, НДШ-ийн зардлыг бууруулж батлах талаар дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Сангийн яамны ирүүлсэн “УИХ-аас баталсан Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд аймгийн суурь зарлагад туссан төсөв, цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан үйл ажиллагаа явуулах” гэсэн чиглэлийг баримталж орон тоо, цалингийн зардлын хязгаарыг баримтлах;

2.3 Байр ашиглалттай холбоотой зардлын төсвийг тооцоо судалгаанд үндэслэж бодитой төлөвлөөгүй байна.

Сангийн яамнаас орон нутгийн 2026 оны төсөвт байр ашиглалттай холбоотой зардлын нийт төсвийг 15,636.9 сая төгрөгөөр хянаж ирүүлснийг 1,399.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж 17,036.7 сая төгрөгөөр төлөвлөсөн байна. Нэмэгдүүлсэн төсвийн 1,291.8 сая төгрөгийг буюу 93 хувийг түлш, халаалтын зардал эзэлж байна.

Хүснэгт 14. Тогтмол зардлын судалгаа (сая төгрөг)

Зардлын зүйл анги	Сангийн яамнаас хянаж ирүүлсэн 2026 оны төсөв	Аймгийн Засаг даргын 2026 оны төсвийн төсөл	Зөрүү
1	2	3	4=3-2
<u>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</u>	<u>15,636.90</u>	<u>17,036.70</u>	<u>1,399.80</u>
Гэрэл, цахилгаан	1,526.10	1,651.40	125.3
Түлш, халаалт	13,063.80	14,355.60	1,291.80
Цэвэр, бохир ус	1,051.50	1,007.70	-43.8
Байрны түрээс	-4.5	22	26.5

Эх сурвалж: Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс ирүүлсэн төсвийн төсөл

Цахилгааны үнэ тарифтай холбоотой цахилгааны зардлыг өмнөх оны гүйцэтгэлээс нэмж төлөвлөсөн байна.

Сангийн яамнаас байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг багцын дүнгээр батлагдаж ирсэн учраас байгууллагуудын төсвийг ямар байдлаар нэмэгдүүлсэн, бууруулсан эсэхэд санал дүгнэлт өгөхөд хүндрэлтэй байна.

Хүснэгт 15. Тогтмол зардлын судалгаа-салбараар (сая төгрөг)

Байгууллагын нэр	Сангийн яамнаас хянасан төсөв	2026 оны төсвийн төсөл	Зөрүү	Хувь
1	2	3	4=3-2	5
<u>Баян-Өлгий</u>	<u>15,636.90</u>	<u>17,036.70</u>	<u>1,399.80</u>	<u>9</u>
Соёлын төв	1,818.30	1,524.50	-293.8	-16.2
ЕБС	6,586.10	7,076.00	489.9	7.4
СӨБ	2,382.80	3,733.20	1,350.50	56.7

“Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх” нийцлийн аудитын тайлан

ЭМТөв	2,948.20	2,732.20	-216	-7.3
Аймаг, сумдын Засаг даргын тамгын газар, баг	1,136.00	1,099.20	-36.9	-3.2
МҮОНРТ-ийн Баян-Өлгий дахь салбар	25.6	30.9	5.3	20.8
Байгаль орчны газар	17.7	21.1	3.4	18.9
Аймгийн асрамжийн газар	24.6	25.3	0.6	2.6
БТСГазар	390.9	419.4	28.5	7.3
Мэргэжлийн боловсролын сургууль	276.7	332.6	55.9	20.2
Засаг даргын ерөнхий данс	29.9	42.2	12.4	41.5

Эх сурвалж: Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс ирүүлсэн төсвийн төсөл

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын нийт төсвийн 41.5 хувийг ЕБС-д, 21.9 хувийг СӨБ-д, 11.9 хувийг Нэгдсэн эмнэлэг болон өрхийн эмнэлгүүдэд, 4.3 хувийг Соёлын төвүүдэд, 4.2 хувийг ЭМТ-үүдэд, 3.5 хувийг аймаг, сумын Засаг даргын тамгын газарт, 3.8 хувийг Хөгжимт драмын театр, 2.5 хувийг БТСГ-т, 2.0 хувийг Мэргэжлийн боловсролын сургуульд, 4.4 хувийг бусад байгууллагуудад хуваарилсан байна.

СӨБ-д 1,350.5 сая төгрөгөөр, ЕБС-д 489.9 сая төгрөгөөр, Мэргэжлийн боловсролын сургуульд 55.9 сая төгрөгөөр, БТСГ-т 28.5 сая төгрөгөөр, зарим байгууллагад 21.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж, Соёлын төвүүдийн төсвийг 293.8 сая төгрөгөөр, ЭМТ-үүдийн төсвийг 216.0 сая төгрөгөөр, зарим байгууллагын төсвийг 36.9 сая төгрөгөөр бууруулсан байна.

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс хүүхдийн арван зургаан цэцэрлэгийн түрээсийн төлбөрт 1,216.2 сая төгрөгийн төсвийг орон нутгаас нэмж төлөвлөжээ. Үүнийг цэцэрлэгүүдийн түрээсийн төлбөрийг төсөвлөж хүргүүлсэн боловч хянаж ирүүлэхдээ хассан гэсэн тайлбар өгч байгаа боловч үүнтэй холбоотой үндэслэлтэй тооцоо судалгаа ирүүлээгүй бөгөөд бодитой эсэх нь эргэлзээтэй байна.

Хүснэгт 16. Тогтмол зардлын харьцуулсан судалгаа (сая төгрөг)

Үзүүлэлт	2024 оны төсөв	2024 оны гүйцэтгэл	2025 оны тодотгосон төсөв	Орон нутгийн 2026 оны төсвийн төсөл
1	2	3	4	5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,186.70	13,685.90	17,844.90	17,036.70
Гэрэл, цахилгаан	948.7	932.9	1,653.90	1,651.40
Түлш, халаалт	12,779.60	11,367.10	15,149.10	14,355.60
Цэвэр, бохир ус	864.3	799.8	1,016.90	1,007.70
Байрны түрээс	594.1	586.1	25	22

Эх сурвалж: Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс ирүүлсэн төсвийн төсөл, аудиторын судалгаа

Тогтмол зардлын 2025 оны тодотгосон төсөв 2024 оны гүйцэтгэлээс 4,159.0 сая төгрөгөөр өссөн, 2026 оны төсөв 2025 оны тодотгосон төсвөөс 808.2 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

2024 оны түрээсийн зардлын 586.1 сая төгрөгийн 569.0 сая төгрөг нь цэцэрлэгийн түрээсийн зардал, 17.1 сая төгрөг нь сургуулийн түрээсийн зардал ба 2026 оны төсвийн төсөлд түрээсийн зардлыг сургууль, цэцэрлэгийн түлш халаалтын зардалд оруулж төлөвлөсөн байна.

“Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх” нийцлийн аудитын тайлан

Хүснэгт 17. Халаалтын болон түрээсийн зардлын судалгаа (сая төгрөг)

Байгууллагын нэр	2024 оны гүйцэтгэл	2026 оны төсвийн төсөл	Зөрүү
1	2	3	4=3-2
Соёлын төв	611.6	714.5	102.9
ЕБС	5,670.40	6,155.00	484.6
СӨБ	1,628.50	3,095.70	1,467.20
ЭМТөв	491.4	562.9	71.6
Сумдын ЗДТГазар	479.7	555.9	76.2
Хөгжимт драмын театр	592.4	592.4	0.1
Номын сан	41.8	38.7	-3.2
Музей	75.3	75.3	0
Засаг даргын тамгын газар	218.6	218.1	-0.5
МҮОНРТ-ийн БӨ салбар	23.1	25	1.9
Байгаль орчин, аялал жуулчлалын газар	16.5	16.1	-0.4
Аймгийн асрамжийн газар	8.8	7.6	-1.2
БТСГазар	364.2	364.2	0.1
Насан туршийн боловсролын төв	5.5	-	-5.5
Мэргэжлийн боловсролын сургууль	283.4	283.4	-
Ахмадын сан	156.4	-	-156.4
Нэгдсэн эмнэлэг болон өрхийн эмнэлэг	699.6	1,451.60	752
Төрийн үйлчилгээний байр	-	164	164
Засаг даргын ерөнхий данс	-	35	35
Байрны түрээс	586.1	22	-564.1
Дүн	11,953.20	14,377.50	2,424.40

Эх сурвалж: Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс ирүүлсэн төсвийн төсөл, аудиторын судалгаа

Аймгийн 2026 оны төсвийн төсөлд халаалтын зардал 2024 оны гүйцэтгэлээс 2,424.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд: Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 1,467.2 сая төгрөгөөр (түрээсийн зардал 586.1 сая төгрөгийг нэгтгэж төсөвлөсөн), Нэгдсэн эмнэлэг болон өрхийн эмнэлэгд 752.0 сая төгрөг, ерөнхий боловсролын сургуульд 484.6 сая төгрөгөөр, төрийн үйлчилгээний байранд 164.0 сая төгрөг, сумдын ЗДТГ-т 76.2 сая төгрөг, эрүүл мэндийн төвүүдэд 71.6 сая төгрөг, соёлын төвийн байгууллагад 99.8 сая төгрөгөөр нэмэгджээ.

ЕБС-ийн 24 сургуулийн халаалтын зардлыг 885.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 11 сургуулийн халаалтын зардлыг 400.5 сая төгрөгөөр бууруулсан боловч үүнтэй холбоотой тооцоо судалгаа бодитой биш байна.

Хүснэгт 18. Халаалтын зардлын төсвийг нэмэгдүүлсэн сургуулиудын судалгаа (сая төгрөг)

Байгууллагын нэр	2024 оны гүйцэтгэл	2026 төсвийн төсөл	Зөрүү
1	2	3	4=3-2
Баяннуур Сургууль	272.7	285.5	12.7
Баяннуур Цагаан арал бага сургууль	18.4	26.9	8.5
Булган 1-р сургууль	166.5	216	49.5
Буянт ЕБСургууль	216.3	413	196.6
Ногооннуур Чихтэй бага сургууль	13	63.8	50.8
Ногооннуур Ховд бага сургууль	10	63.8	53.8

“Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх” нийцлийн аудитын тайлан

Ногооннуур Улаанчулуут бага сургууль	14	63.8	49.8
Ногооннуур ЕБСургууль	61.3	76.2	14.9
Ногооннуур 2-р сургууль	0	20	20
Улаанхус ЕБСургууль	275.2	310.8	35.6
Улаанхус Согог сургууль	78.2	120	41.8
Улаанхус Хөх хөтөл сургууль	65.3	150	84.7
Цэнгэл 3-р сургууль	19.3	78.4	59.1
Цэнгэл ЕБСургууль	230.6	260.6	30.0
Өлгий 8-р сургууль/30 дугаар цэцэрлэг	16.8	145.4	128.6
Дүн	1,457.60	2,294.20	836.6

Эх сурвалж: Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс ирүүлсэн төсвийн төсөл, аудиторын судалгаа

Буянт сумын ЕБС-д 320 хүүхдийн хүчин чадалтай хичээлийн шинэ байр ашиглалтанд орсон, Өлгий сумын 8 дугаар сургууль/30 дугаар цэцэрлэг 2025 оны 11 дүгээр сард хичээлийн шинэ байр ашиглалтад орсон, Ногооннуур сумын 2 дугаар сургуулийн барилга шинээр ашиглалтанд орсон ба одоогоор үйл ажиллагаа эхлээгүй байгаагаас халаалтын зардлын төсөв нэмэгдсэн байна.

Баяннуур, Булган сумын ЕБС, Цагаан арал бага сургуулиудад биеийн тамирын заал шинээр ашиглалтад орсон, Улаанхус сумын Хүүхэд хөгжлийн заалыг засварлаж халаалтад холбосон гэх ба бусад сургуулиудын талбайд өөрчлөлт ороогүй боловч нүүрсний үнэ өссөн, галлагааны пийшингийн тоо нэмэгдсэн зэрэг тайлбарыг өгсөн.

Мөн хүүхдийн 43 цэцэрлэгийн халаалт, түрээсийн зардлыг 953.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 11 цэцэрлэгийн зардлыг 55.5 сая төгрөгөөр бууруулсан байна. Түлш, халаалтын зардал нь нэмэгдсэн цэцэрлэгүүдийн дийлэнх нь түрээсийн байранд үйл ажиллагаа явуулдаг байна.

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс ирүүлсэн судалгаанаас үзэхэд 8 цэцэрлэг, 7 салбар бүлгийн түрээсийн зардалд 1,023.2 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Хүснэгт 19. Цэцэрлэгүүдийн түрээсийн судалгаа (мянган төгрөг)

Түрээсэлж байгаа хэлбэр	Цэцэрлэгүүд	Байрны зориулалт	Талбайн хэмжээ	Сарын түрээсийн төлбөр	Жилийн түрээс	М.кв-ын төлбөр
1	2	3	4	5	6	7
Түрээсийн байранд үйл ажиллагаа явуулдаг	Өлгий сумын 10-р цэцэрлэг	Үйлчилгээний	517.5	9,400.00	112,800.00	18.2
	Өлгий сумын 11-р цэцэрлэг	Үйлчилгээний	693.8	11,800.00	141,600.00	17
	Өлгий сумын 23-р цэцэрлэг	Үйлчилгээний	648	4,600.00	55,200.00	7.1
	Өлгий сумын 24-р цэцэрлэг	Үйлчилгээний	650	6,500.00	78,000.00	10
	Өлгий сумын 32-р цэцэрлэг	Үйлчилгээний	892	12,500.00	150,000.00	14
	Дэлүүн сумын 3-р цэцэрлэг	Үйлчилгээний	390	3,500.00	42,000.00	9
	Алтай сумын 2-р цэцэрлэг	Хувийн сууц	289	5,500.00	66,000.00	19
	Толбо сумын 2-р цэцэрлэг	Хувийн сууц	200	5,000.00	60,000.00	25
Өлгий сумын 27-р цэцэрлэг	Хувийн сууц	162.7	5,000.00	60,000.00	30.7	
Салбар бүлгүүд нь түрээсийн байранд үйл	Өлгий сумын 15-р цэцэрлэг	Хувийн сууц	120	2,800.00	33,600.00	23.3
	Өлгий сумын 18-р цэцэрлэг	Хувийн сууц	168	5,500.00	66,000.00	32.7
	Өлгий сумын 19-р цэцэрлэг	Үйлчилгээний	292	5,000.00	60,000.00	17.1
	Өлгий сумын 9-р цэцэрлэг	Хувийн сууц	180	3,000.00	36,000.00	16.7

“Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх” нийцлийн аудитын тайлан

ажиллагаа явуулдаг	Өлгий сумын 13-р цэцэрлэг	Хувийн сууц	227	5,000.00	60,000.00	22
	Өлгий сумын 17-р цэцэрлэг	Хувийн сууц	397.5	4,500.00	54,000.00	11.3
	Улаанхус сумын 4-р цэцэрлэг	Үйлчилгээний	360	4,000.00	48,000.00	11.1
	Дүн		6187.5		1,023,200.00	

Эх сурвалж: Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс ирүүлсэн судалгаа

Түрээсийн байрны метр квадртын төлбөр Алтай, Дэлүүн, Толбо, Улаанхус сумдад 9.0-20.6 мянган төгрөг, Өлгий суманд 7.1-30.7 мянга төгрөгийн хооронд харилцан адилгүй байгаа нь түрээсийн зардал өндөр гарахад нөлөөж байгаа ба тооцоо нь үнэн зөв эсэх нь эргэлзээтэй байна.

Аудитын явцад цэцэрлэгүүдийн түрээсийн гэрээг авч ирүүлсэн судалгаатай тулган үзэхэд зарим цэцэрлэгийн түрээсийн төлбөр, талбайн хэмжээ, мөнгөн дүн зөрүүтэй байна.

Алтанцөгц сумын Хар үзүүрийн гүүр 2025 оны намар ашиглалтад орсноор Хотгорын нүүрсний уурхайгаас нүүрс тээвэрлэх зам 100 км-ээр богино болсон нь Алтанцөгц, Баяннуур сумдын төсөвт байгууллагуудын халаалтын үнэ тарифт бодитой нөлөөлөх тул үнэ тарифыг дахин хянаж батлах шаардлагатай байна. Шүүхийн шийдвэрээр төсвөөс нөхөн төлөх 8 байгууллагын 820.7 сая төгрөгийн он дамжсан халаалтын өртэй байна.

Хүснэгт 20. Халаалтын он дамжсан өрийн судалгаа (сая төгрөг)

Байгууллагын нэр	Шүүхийн шийдвэрийн дүн	2025.11.25-ны өдрийн байдлаар төлсөн дүн	Үлдэгдэл
1	2	3	4=3-2
Мэргэжлийн боловсролын сургууль	53.4	53.3	0.1
Өлгийн сумын ЕБ-ын 2 дугаар сургууль	227.1	65	162.1
Өлгийн сумын ЕБ-ын 3 дугаар сургууль	171.6	33.5	138.1
Өлгийн сумын ЕБ-ын 4 дүгээр сургууль	155.8	-	155.8
Өлгий сумын Хүүхдийн 2-р цэцэрлэг	27.4	10.8	16.6
Хөгжимт драмын театр	209.3	-	209.3
Биеийн тамир спортын газар	89.7	19.2	70.5
Нэгдсэн эмнэлэг	205.7	137.5	68.2
Дүн	1140.0	319.3	820.7

Эх сурвалж: “Эрчим Баян-Өлгий” ХХК-аас авсан судалгаа

Аймгийн Засаг даргын ангилагдаагүй зардлын 2026 оны төсөвт 600.0 сая төгрөгийг шүүхийн шийдвэрээр өр барагдуулахад тусгасан байна. Санхүү, төрийн сангийн хэлтсээс Нэгдсэн эмнэлгийн 68.2 сая төгрөгийн өр нь орон нутгийн төсөвт шилжиж ирэхээс өмнө үүссэн өр учраас хариуцахгүй гэсэн тайлбар өгсөн.

Аудитын явцад шинээр нэмэгдэх байгууллагууд болон барилгын талбай нэмэгдүүлсэн талаар эрх бүхий байгууллагын зөвшөөрөл, цэцэрлэгийн түрээслэх барилга нь стандарт шаардлагад нийцэж байгаа эсэхэд хийсэн дүн шинжилгээ, халаалтын талбай болон зуухны тоог хянан баталгаажуулсан талаар баримт материалыг ирүүлээгүй болно.

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийн төлөвлөлтийг сайжруулах, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэхтэй холбоотой дараах саналыг хүргэж байна. Үүнд:

- 1.Төсөвт байгууллагуудын халаалтын талбайн хэмжээг хянан баталгаажуулж, халаалтын зардлыг бодитой төлөвлөхөд анхаарах;
- 2.Цэцэрлэгүүдийн түрээсийн төлбөрийн жишиг үнийг тогтоож, үр ашигтай байдлаар гэрээ хийж, төсвийн зардлыг бууруулахад анхаарах;
- 3.Алтанцөгц, Баяннуур сумын төсөвт байгууллагуудын халаалтын үнэ тарифыг дахин хянаж батлах, түлш, халаалтын зардлыг бууруулах;
- 4.Шүүхийн шийдвэрээр төлөх он дамжсан халаалтын зардлын өр төлбөрийг тухайн байгууллагуудын төсөвт суулган бүрэн барагдуулах арга хэмжээ авах;
- 5.Ногооннуур, Улаанхус, Цэнгэл сумдын сургуулиудын халаалтын зардлын төсвийг бодитой тооцож, зардлыг бууруулж төлөвлөх;

2.4 Орон нутгийн төсвийн төсөлд урсгал зардлыг үндэслэлгүй нэмэгдүүлсэн нь төсвийг хэмнэлттэй, үр ашигтай байх зарчимд нийцээгүй байна

Аймгийн Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд зарлагыг Сангийн Яамнаас ирүүлсэн хязгаараас 10,736.6 сая төгрөгөөр тооцоо, судалгаагүйгээр нэмэгдүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг хэмнэлттэй, үр ашигтай байдлаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “үр ашигтай байх”, 4.1.6-д “сахилга баттай байх”, 4.1.9-д “хариуцлагатай байх” гэсэн зарчимтай нийцэхгүй байна.

Тухайлбал: Аймгийн ИТХ болон аймгийн Засаг даргын Тамгын газрын зардлын төсвийг үндэслэлгүйгээр нэмэгдүүлсэн, Сангийн яамнаас хянаж ирүүлсэн орон тооны хязгаарыг баримтлаагүй, цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг нэмэгдүүлж төлөвлөсөн, байр ашиглалттай холбоотой зардлыг үндэслэлгүйгээр нэмэгдүүлсэн зэрэг нь төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байх зарчимд нийцээгүй байна.

БҮЛЭГ 3. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ НЬ ХУУЛЬД ЗААСАН ШААРДЛАГЫГ ХАНГААГҮЙ БАЙНА

3.1 Орон нутгийн хөгжлийн сангийн төсөл арга хэмжээг хууль тогтоомжид нийцүүлэн төлөвлөх шаардлагатай байна

Сангийн яамнаас орон нутгийн хөгжлийн сангийн 2025 оны төсвийг 10,828.9 сая төгрөгөөр хянаж ирүүлсэн. Үүнээс аймгийн Орон нутгийн хөгжлийн санд 3,893.6 сая төгрөг, сумдын орон нутгийн хөгжлийн санд 6,935.3 сая төгрөг хуваарилсан байна.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн санд он дамжсан шилжих хөрөнгө оруулалтад 2,173.7 сая төгрөгийн 15 төсөл, арга хэмжээг, шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтад 1,719.9 сая төгрөгийн 44 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Аймгийн хөгжлийн 2026 оны жилийн төлөвлөгөөнд тусгаагүй 1,683.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 840.9 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 9 төсөл, арга хэмжээг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.1¹ дахь заалтад нийцэхгүй байна.Үүнд:

¹ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх

“Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх” нийцлийн аудитын тайлан

Хүснэгт 21. Аймгийн хөгжлийн 2026 оны жилийн төлөвлөгөөнд тусгаагдаагүй төсөл, арга хэмжээ (сая.төгрөг)

№	Төсөл арга хэмжээний нэр хүчин чадал, байршил	Эхлэх, дуусах хугацаа	Төсөвт өртөг	Санхүүжих дүн /2026 он
1	Дэлүүн сумын 12 дугаар багт цэцэрлэгт хүрээлэн байгуулах	2026-2027	139.0	69.0
2	Ногооннуур сумын 1 дүгээр цэцэрлэгийн барилгын гадна фасадын засвар	2026-2027	325.0	122.0
3	Сагсай сумын төвд спорт цогцолбор барих	2026-2027	400.0	190.0
4	Өлгий сумын 8 дугаар багт явган хүний зам тавих	2026-2027	139.0	69.0
5	Өлгий сумын 1 дүгээр багт хүүхдийн тоглоомын талбай барих	2026-2027	100.0	30.0
6	Өлгий сумын 12 дугаар багт явган хүний зам тавих	2026-2027	80.0	40.9
7	1-60 айлын орон сууцны гадна тохижилт	2026-2027	80.0	40.0
8	2-60 айлын орон сууцны гадна хаалганы засвар	2026-2026	20.0	10.0
9	Өлгий сумын төв талбай орчмын гудамжны тохижилт	2026-2027	400.0	270.0
Дүн			1,683.00	840.9

Эх сурвалж: Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсээс ирүүлсэн төсвийн төсөл

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөөнд ажлын зураг төсөв, техникийн тодорхойлолтгүй, хуульд заасан бусад зөвшөөрөлгүй 638.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 463.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 19 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5², “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.1.3³ дах заалттай нийцэхгүй байна. Үүнд:

Хүснэгт 22. Зураг төсөв, техникийн тодорхойлолтгүй, хуульд заасан холбогдох зөвшөөрөл олгогдоогүй ТАХ-ний судалгаа (сая төгрөг)

№	Төсөл арга хэмжээний нэр хүчин чадал, байршил	Эхлэх, дуусах хугацаа	Төсөвт өртөг	Санхүүжих дүн /2026 он
1	Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуульд жудо бөхийн дэвжээ нийлүүлэх	2026-2026	17.0	17.0
2	Алтай сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгт тоног төхөөрөмж	2026-2026	13.0	13.0
3	Баяннуур сумын 2 дугаар бага сургуульд тоног төхөөрөмж нийлүүлэх	2026-2026	20.0	20.0
4	Баяннуур сумын 3 дугаар цэцэрлэгт тоног төхөөрөмж нийлүүлэх	2026-2026	20.0	20.0
5	Булган сумын цэцэрлэгийн салбар бүлэг цэцэрлэгийг тохижуулах, тоглоом худалдан авах	2026-2026	18.0	18.0
6	Булган сумын “Сөнхөл” багийн Ерөнхий боловсролын сургуульд тоног төхөөрөмж, эд хогшил нийлүүлэх	2026-2026	18.0	18.0
7	Буянт сумын цэцэрлэгт тоног төхөөрөмж нийлүүлэх	2026-2026	10.0	10.0

⁴² Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зөвхөн орон нутгийн иргэдийн санал авсан, хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан холбогдох зөвшөөрөл олгогдсон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ”

³³ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон байх;

“Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх” нийцлийн аудитын тайлан

8	Буянт сумын Өмнөгол багийн үүрэн холбооны 4 G сүлжээний тоног төхөөрөмж нийлүүлэх	2026-2027	150.0	50.0
9	Сагсай сумын төвд спорт цогцолбор барих	2026-2027	400.0	190.0
10	Толбо сумын Мал эмнэлгийн тасагт ариутгалын зориулалттай Дук машин худалдан авах	2026-2026	70.0	70.0
11	Цэнгэл сумын 5 дугаар цэцэрлэгт тоног төхөөрөмж нийлүүлэх	2026-2026	10.0	10.0
12	Өлгий сумын төв талбай орчмын гудамжны тохижилт	2026-2027	400.0	270.0
13	Нэгдсэн эмнэлгийн төрөх тасаг болон мэс заслын тасагт тоног төхөөрөмж нийлүүлэх	2026-2027	44.0	9.0
14	Өлгий сумын 26 дугаар цэцэрлэгт хөгжмийн зэмсэг	2026-2026	17.0	17.0
15	Өлгий сумын 8 дугаар цэцэрлэгт эд хогшил нийлүүлэх	2026-2026	10.0	10.0
16	Өлгий сумын 3 дугаар багт шинээр барих цэцэрлэгийн зориулалттай газар худалдан авах	2026-2027	60.0	50.0
17	Өлгий сумын 1 дүгээр багт хүүхдийн тоглоомын талбай барих зориулалтаар газар худалдан авах	2026-2026	75.0	75.0
18	Аймгийн нэгдсэн эмнэлэгт тоног төхөөрөмж нийлүүлэх	2026-2026	20.0	20.0
19	Аймгийн нэгдсэн эмнэлэгт зөөврийн лабораторийн тоног төхөөрөмж худалдан авах	2026-2026	12.0	12.0
Нийт /19 төсөл, арга хэмжээ/			638.0	463.0

Эх сурвалж: Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсээс ирүүлсэн төсвийн төсөл

“Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.2⁴-т аймаг, нийслэлийн түвшинд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх чиг үүргийг тусгасан ба Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.2-т “хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ”, 13.4.6-т “нийтийн эзэмшлийн байр, орон сууцны засвар, шинэчлэл” гэж заажээ.

2026 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 44 төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон Орон нутгийн хөгжлийн сангийн журмын хүрээнд төлөвлөсөн эсэхийг хянаж үзэхэд аймгийн Орон нутгийн хөгжлийн ийн чиг үүрэгт хамааралгүй тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжгүй 80.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 40.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй Өлгий сумын 1-60 айлын орон сууцны гадна тохижилт, 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 2-60 айлын гадна хаалганы засварын ажлыг төсвийн төсөлд тусгасан байна.

3.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээ хууль тогтоомжид нийцээгүй, Замын сангийн төсвийг үр ашигтай төлөвлөөгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын шилжих хөрөнгө оруулалтаар 1,104.3 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээг, шинээр хэрэгжүүлэх 2,154.3 сая төгрөгийн 36 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

Аймгийн хөгжлийн 2026 оны жилийн төлөвлөгөөнд тусгаагүй 1,128.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 628.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 6 ТАХ-г төлөвлөсөн нь

² Аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хууль болон энэхүү журмын хориглосон заалтад тусгаадаагүй дараах чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ.

“Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх” нийцлийн аудитын тайлан

Төсвийн тухай хуулийн 24 дугаар зүйлийн 24.6⁵, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.1.1⁶-д нийцэхгүй байна.

Хүснэгт 23. Аймгийн хөгжлийн 2026 оны жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй орон нутгийн хөрөнгө оруулалт (сая төгрөг)

№	Төслийн нэр	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	Ирэх онд санхүүжих дүн
1	Шинэ захын засвар	2026	2027	400.0	200.0
2	Аймгийн ЦШСГ-ын байрны засвар	2026	2026	200.0	100.0
3	Шуурхай удирдлага мэдээллийн төвийн засвар	2026	2026	50.0	50.0
4	Олон нийтийн парк шинээр байгуулах	2026	2027	400.0	200.0
5	Нийгмийн даатгалын газарт өрөө худалдан авах	2026	2026	48.0	48.0
6	Татварын газрын барилгын засвар	2026	2026	30.0	30.0
Нийт /6 төсөл, арга хэмжээ/				1,128.00	628.0

Эх сурвалж: Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсээс ирүүлсэн төсвийн төсөл

Мөн Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад ажлын зураг төсөв, техникийн тодорхойлолтгүй, хуульд заасан бусад зөвшөөрөлгүй 1,200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 650.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 7 ТАХ-г төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4⁷, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-ийн 13.3.3⁸-д нийцэхгүй байна. Үүнд:

Хүснэгт 24. Зураг төсөв, техникийн тодорхойлолтгүй, хуульд заасан холбогдох зөвшөөрөл аваагүй ТАХ-ний судалгаа -Орон нутгийн хөрөнгө оруулалт (сая төгрөг)

№	Төслийн нэр	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	Ирэх онд санхүүжих дүн
1	Ухаалаг тоолуур худалдан авах	2026	2026	300.0	150.0
2	Аялал жуулчлалын бүс нутгуудад отоглох, хоноглох цэг байгуулах	2026	2026	20.0	20.0
3	Шуурхай удирдлага мэдээллийн төвд тоног төхөөрөмж худалдан авах	2026	2027	300.0	100.0
4	Шуурхай удирдлага мэдээллийн төвийн засвар	2026	2026	50.0	50.0
5	Аялал жуулчлалын бүс нутгуудад эко ариун цэврийн байгууламж, нэгдсэн хогийн цэг барих	2026	2026	50.0	50.0
6	Аймгийн төвийн камержуулалтыг нэмэгдүүлэх	2026	2026	80.0	80.0
7	Олон нийтийн парк шинээр байгуулах	2026	2027	400.0	200.0
Нийт /7 төсөл, арга хэмжээ/				1,200.00	650.0

Эх сурвалж: Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсээс ирүүлсэн төсвийн төсөл

⁵ Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”

⁶ Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулах, хөгжлийн бодлого, зорилго болон зорилтыг хангах зорилгоор цахим системийн бодлогын дэд системд хөгжлийн бодлогын баримт бичгийг дараах байдлаар холбоно:

⁷ “хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана”,

⁸ “Техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ”

Боловсрол, соёл, эрүүл мэндийн салбарын засварын хөрөнгөөр 2026 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ

Боловсрол, соёл, эрүүл мэндийн салбарын их завсарт шилжих хөрөнгө оруулалтаар 4.070,9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1,356.7 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 9 төсөл, арга хэмжээ, шинээр хэрэгжүүлэх 1,606.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1,000.6 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 33 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

Шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээнээс боловсролын салбарын их засварт 1,140.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 727.6 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 24 төсөл, арга хэмжээ, эрүүл мэндийн салбарын их засварт 427.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 234.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 7 төсөл, арга хэмжээ, соёлын салбарын их засварт 39.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 39.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 2 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн гал тогооны засварын 46.3 сая төгрөгийн санхүүжих дүнтэй төсөл, арга хэмжээг шилжих хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч энэ нь өмнөх оны төсөвт тусгагдаагүй байна.

Замын сан - Замын санд шилжих хөрөнгө оруулалтаар 217.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 137.8 санхүүжих дүнтэй 3 төсөл, арга хэмжээ, шинээр хэрэгжүүлэх 1,497.2 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 5 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

Замын сангийн хөрөнгөөр шинээр хэрэгжих 1,277.2 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 3 төсөл, арга хэмжээ нь зураг төсөвгүй, хуульд заасан бусад зөвшөөрөлгүй, нийт дүнгээр төлөвлөгдсөн нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4⁹, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-ийн 13.3.3¹⁰-д нийцэхгүй байна.

Хүснэгт 25. Зураг төсөвгүй, хуульд заасан холбогдох зөвшөөрөл аваагүй, нийт дүнгээр төлөвлөсөн Замын сангийн хөрөнгийн (сая төгрөг)

№	Төслийн нэр	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	Ирэх онд санхүүжих дүн
1	Гүүр шинээр барих, засварлах	2026	2026	200.0	200.0
2	Сумдын замын засвар	2026	2026	200.0	200.0
3	Бусад	2026	2026	877.2	877.2
	Нийт /3 төсөл, арга хэмжээ/			1,277.20	1,277.20

Эх сурвалж: Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсээс ирүүлсэн төсвийн төсөл

Төсвийн хөрөнгө орон нутгийн төсөлд зарлага бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх дараах саналуудыг хүргүүлж байна. Үүнд:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалт, ОНХС, Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зураг төсөв нь батлагдаагүй, техникийн тодорхойлолтгүй, хуулийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээнүүдийг хууль тогтоомжид нийцүүлэх;
2. Аймгийн Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан, төлөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг батлах;
3. Орон нутгийн хөгжлийн сангийн чиг үүрэгт хамааралгүй, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжгүй 40.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй Өлгий сумын 1-60 айлын орон сууцны гадна тохижилт, 10.0 сая өгрөгийн санхүүжих дүнтэй 2-60 айлын гадна хаалганы засварын ажлын төсвийг хасах;

⁷ “хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана”,

⁸ “Техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ”

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Орон нутгийн төсвийн суурь орлогын төсвийг бодит тооцоо, судалгаанд үндэслээгүй байна.
2. Сумуудын татварын орлогыг нэмэгдүүлэх боломжуудыг бүрэн тооцож төлөвлөөгүй байна.
3. Аймгийн ИТХ болон Засаг даргын тамгын газрын төсвийг 3,445.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна
4. Сангийн яамнаас хянасан орон тооны хязгаарыг баримтлаагүй, цалин, НДШ-ийн зардлын төсвийг 1,351.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна.
5. Байр ашиглалттай холбоотой зардлын төсвийг тооцоо судалгаанд үндэслэж бодитой төлөвлөөгүй байна.
6. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь хуульд заасан шаардлагыг хангаагүй байна.

ХАВСРАЛТ

Хавсралт 1. Төсвийн суурь орлогын 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл (сая төгрөг)

ҮЗҮҮЛЭЛТ	Тодотгосон төлөвлөгөө	Хүлээгдэж буй гүйцэтгэл	Зөрүү
	a	b	c=b-a
НИЙТ ОРЛОГО	42,113.38	38,671.68	(3,441.69)
ТАТВАРЫН ОРЛОГО	36,591.21	35,496.33	(1,094.88)
Орлогын албан татвар	36,591.21	35,496.33	(1,094.88)
Хувь хүний орлогын албан татвар	32,800.27	32,210.32	(589.95)
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	26,163.42	25,338.91	(824.51)
Үйл ажиллагааны орлого	838.23	392.99	(445.24)
Хөрөнгийн орлого	4,848.62	5,859.30	1,010.68
Хөрөнгө борлуулсны орлого	950.00	619.13	(330.88)
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(2,435.37)	(2,435.37)	(0.00)
Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	1,100.00	906.22	(193.78)
Хөрөнгийн албан татвар	1,943.08	1,801.72	(141.36)
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	523.00	509.55	(13.45)
Бууны албан татвар	60.00	50.51	(9.49)
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	1,152.00	1,007.81	(144.19)
Малын тоо толгойн албан татвар	208.08	233.84	25.76
Бусад татвар	3,183.22	3,013.44	(169.79)
Бусад нийтлэг төлбөр, хураамж	899.26	785.08	(114.17)
Улсын тэмдэгтийн хураамж	772.52	663.77	(108.75)
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	92.24	75.00	(17.23)
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	34.50	46.31	11.81
Газрын төлбөр	704.00	689.35	(14.65)
Үүнээс: Газрын төлбөр	604.00	589.35	(14.65)
Дуудлага худалдаа, сонгон шалгаруулалт	100.00	100.00	-
Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,579.97	1,539.00	(40.96)
Ойн нөөц ашигласны төлбөр	44.00	41.27	(2.73)
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	1,497.97	1,470.55	(27.42)
Ус рашааны нөөц ашигласны төлбөр	38.00	27.18	(10.82)
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,522.17	3,175.35	(2,346.82)
Нийтлэг татварын бус орлого	5,522.17	3,175.35	(2,346.82)
Торгуулийн орлого	2,232.07	1,516.57	(715.50)
Төсвийн байгууллагын өөрийн орлого	65.00	65.00	-
Нэр заагдаагүй бусад орлого	3,225.10	1,593.78	(1,631.32)

“Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх” нийцлийн аудитын тайлан

Хавсралт 2.

Татварын орлогын төсвийн төсөл

(сая төгрөг)

Орлогын нэр төрөл	Хүлээгдэж буй гүйцэтгэл	Сангийн яамны хянаж ирүүлсэн дүн	2026 оны төсвийн төсөл	Зөрүү
	a	b	c	d=c-b
ТАТВАРЫН ОРЛОГО	35,496.33	32,659.92	40,696.47	8,036.56
Орлогын албан татвар	35,496.33	32,659.92	40,696.47	8,036.56
Хувь хүний орлогын албан татвар	32,210.32	29,710.00	36,737.06	7,027.06
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	25,338.91	26,140.00	31,660.00	5,520.00
Үйл ажиллагааны орлого	392.99	600.00	1,104.19	504.19
Хөрөнгийн орлого	5,859.30	2,120.00	3,122.86	1,002.86
Хөрөнгө борлуулсны орлого	619.13	850.00	850.00	-
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(2,435.37)	(2,450.00)	(2,450.00)	-
Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	906.22	1,150.00	1,150.00	-
Хөрөнгийн албан татвар	1,801.72	1,420.50	2,430.00	1,009.50
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	509.55	470.00	920.00	450.00
Бууны албан татвар	50.51	60.00	60.00	-
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	1,007.81	890.50	1,450.00	559.50
Малын тоо толгойн албан татвар	233.84	-	-	-
Бусад татвар	3,013.44	2,829.42	2,829.42	-
Бусад нийтлэг төлбөр, хураамж	785.08	783.00	783.00	-
Улсын тэмдэгтийн хураамж	663.77	693.00	693.00	-
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	75.00	55.00	55.00	-
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	46.31	35.00	35.00	-
Газрын төлбөр	689.35	609.00	609.00	-
Үүнээс: Газрын төлбөр	589.35	609.00	609.00	-
Дуудлага худалдаа, сонгон шалгаруулалт	100.00	-	-	-
Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,539.00	1,437.42	1,437.42	-
Ойн нөөц ашигласны төлбөр	41.27	34.50	34.50	-
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	1,470.55	1,384.58	1,384.58	-
Ус рашааны нөөц ашигласны төлбөр	27.18	18.33	18.33	-

“Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх” нийцлийн аудитын тайлан

Хавсралт 3.

Төсвийн төлөвлөгөө, төсөл байгууллагаар

(сая төгрөг)

Байгууллагын нэр	Сангийн яамнаас хянагдсан	Аймгийн ИТХ-д өргөн мэдүүлсэн	Зөрүү	Зөрүү
	/б/	/в/	/б-а/	/в-б/
НИЙТ	47,754.10	58,490.50	-11,539.20	10,736.40
Бө. Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1,033.60	1,713.60	-375.6	680
Сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	2,963.40	2,640.10	431.5	-323.3
Бө. Засаг дарга	447.6	460	-1,766.90	12.4
Бө. Засаг даргын тамгын газар	3,956.30	8,516.80	-3,069.40	4,560.50
Бө. Орон нутгийн хөрөнгө оруулалт	2,357.30	5,526.20	-3,933.10	3,168.90
Бө. Замын сан	1,635.00	1,635.00	453	-
Сумдын ЗДТГ, Багийн Засаг дарга	14,176.80	16,003.10	-1,337.60	1,826.30
Асрамжийн газар	382.3	411.9	-31.2	29.6
Байгаль орчны газар	1,759.00	1,246.80	340.1	-512.2
МҮОНРТ-ийн Баян-Өлгий дахь салбар	649.1	759.3	-176.2	110.2
Орон нутгийн өмчийн газар	335.1	382.1	-166.3	47
Санхүүгийн хяналт, аудитын алба	322.8	388.2	-34.3	65.4
Сум дундын ойн анги	203.7	330.5	-148.5	126.8
Бө. Халамжийн сан	341.7	341.7	283.2	-
Худалдан авах хэлтэс	245	423.8	-139.8	178.8
Насан туршийн боловсролын төв		10	-10	10
Хот тохижуулах алба	945.7	945.7	-250.9	-
Төрийн үйлчилгээний төв		213.1	-213.1	213.1
Архивын хэлтэс		353.6	-242.9	353.6
БТСГ-ын тогтмол	397.3	425.8	-20	28.5
МСҮТ-ийн тогтмол зардал	281.1	342.6	-94.8	61.5
ЕБС-ийн тогтмол	6,629.70	7,150.00	-1,163.20	520.3
СӨБ-ийн тогтмол зардал	2,406.30	3,784.00	-1,303.00	1,377.70
ЭМТ-н тогтмол	3,252.20	832.9	2,391.30	-2,419.30
Соёлын төвүүдийн тогтмол	1,827.30	747.4	1,076.00	-1,079.90
Хөгжимт драмын театрын тогтмол зардал	1,205.80	641.4	565.4	-564.4
Номын сангийн тогтмол зардал		56.1	-56.1	56.1
Аймгийн Музейн тогтмол зардал		97.9	-98.9	97.9
Нэгдсэн эмнэлэг болон өрхийн эмнэлэг тогтмол зардал		2,110.90	-2,447.90	2,110.90

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 12 сарын 01 өдөр

Дугаар А/32

Өлгий

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын хавсралтын 18 дугаар зүйлийн 18.9 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1 дүгээр зүйлийн 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд санал дүгнэлт өгөх” нийцлийн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2.Аудитын тайланг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймгийн Засаг даргад хүргүүлсүгэй.

3.Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 5 хоногт батгаан аудитын ажлын болон нотлох баримтуудыг архивын нэгж болгон бичиг хэрэгт хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (Д.Назгүл)-д даалгасугай.



Ж.АЙГҮЛ

832501000062